



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 68

Мандалговь

**Г.Дэлгэрмааг Мал эмнэлгийн газрын Сайхан-Овоо
сумын Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчийн
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 6 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Аймгийн Мал эмнэлгийн газрын Сайхан-Овоо сумын Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Гэрэл овогтой Дэлгэрмаа 62.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Г.Дэлгэрмаагийн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2022 оны .../... дугаар сарын
.../...-ны өдрийн .../... дугаар тогтоолын хавсралт



**Мал эмнэлгийн газрын Сайхан-Овоо сумын
Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчийн албан тушаалд
нэр дэвшүүлсэн Г.Дэлгэрмаагийн тухай дүгнэлт**

1. Г.Дэлгэрмаа нь 1995 онд Дундговь аймгийн Адаацаг суманд төрсөн. 27 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2012-2017 онд Монгол Улсын Хөдөө аж ахуйн их сургуулийг Малын их эмч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Г.Дэлгэрмаагийн тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Мал эмнэлгийн газрын Сайхан-Овоо сумын Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ